



2021/2022

Тархаасан: 2022 оны 1 дүгээр сарын 15



2021/2022 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын сургуулийн 1-р ангид 75.5 мянган хүүхэд шинээр элсэн орсны 88.5 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна

Улсын хэмжээнд 2021/2022 оны хичээлийн жилийн эхний байдлаар 1453 цэцэрлэг, 848 ерөнхий боловсролын сургууль (ЕБС), 76 техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, 88 их, дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 1. БҮХ ШАТНЫ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА, өмчийн хэлбэрээр, 2021/2022 оны хичээлийн жилийн эхэнд

Сургалтын байгууллагын төрөл	Сургалтын байгууллага			
	Нийт	Төрийн	Хувийн	Олон нийтийн/ шашны
Цэцэрлэг	1 453	972	481	-
Ерөнхий боловсролын сургууль	848	682	166	-
Бага	72	52	20	-
Дунд	109	108	1	-
Ахлах	667	522	145	-
Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага	76	43	33	-
Дээд боловсролын сургалтын байгууллага	88	20	65	3

2021/2022 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 712.4 (65.1%) мянга, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад 42.6 (3.9%) мянга, их, дээд сургууль, коллежид 149.0 (13.6%) мянган хүүхэд, залуучууд суралцаж байна.

Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-д хамрагдсан хүүхдийн тоо 191.0 мянга болж өмнөх оноос 56.0 (22.7%) мянгаар буурсан нь ковид-19 цар тахлын улмаас 4-5 настай хүүхдийг үндсэн сургалтад хамруулж, 3 настай хүүхдийн хөгжлийг гэр бүлд түшиглэн зайны хэлбэрээр дэмжин ажиллаж байгаатай холбоотой.

Энэ хичээлийн жилд ЕБС-ийн 1 дүгээр ангид 75.5 мянган хүүхэд шинээр элссэний 88.5 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна.

ХҮСНЭГТ 2. БҮХ ШАТНЫ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧИД, хичээлийн жилийн эхэнд

Сургалтын байгууллагын төрөл	2017/2018	2018/2019	2019/2020	2020/2021	2021/2022
Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	256 720	261 354	263 333	247 040	190 991
Эмэгтэй	126 610	128 021	128 946	120 955	93 362
Ерөнхий боловсролын сургууль	572 752	593 150	640 449	680 837	712 353
Эмэгтэй	286 014	295 558	319 912	339 681	355 170
Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага	35 831	37 039	37 806	40 165	42 594
Эмэгтэй	13 941	14 589	15 547	15 987	17 063
Дээд боловсролын сургалтын байгууллага	155 248	157 625	148 446	147 293	148 954
Эмэгтэй	90 094	93 552	90 573	89 463	91 034

Улсын хэмжээнд 2021/2022 оны хичээлийн жилийн эхэнд цэцэрлэгт нийт 8.8 мянган багш ажиллаж байгаа бөгөөд цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо 22 болж өмнөх оноос 4-өөр буурчээ. Нэг багшид ногдох хүүхдийн тоо төрийн өмчийн цэцэрлэгийн хувьд 21, харин хувийн цэцэрлэгийн хувьд 24 байна.

ЕБС-д 35.1 мянган багш ажиллаж байгаагийн 31.2 (88.7%) мянга нь төрийн өмчийн, 4.0 (11.3%) мянга нь хувийн өмчийн сургуульд ажиллаж байна. ЕБС-ийн нэг багшид ногдох суралцагчдын тоо 2021/2022 оны хичээлийн жилд 20 байгаа бөгөөд сургуулийн өмчийн хэлбэрээс хамааран ялгаатай байна.

ХҮСНЭГТ 3. БҮХ ШАТНЫ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН БАГШ, СУРАЛЦАГЧ-БАГШИЙН ХАРЬЦАА, өмчийн хэлбэрээр, 2021/2022 оны хичээлийн жилийн эхэнд


Сургалтын байгууллагын төрөл	Үндсэн багш				Суралцагч-багшийн тооны харьцаа			
	Нийт	Төрийн	Хувийн	Олон нийтийн/ шашны	Нийт	Төрийн	Хувийн	Олон нийтийн/ шашны
Цэцэрлэг	8 824	7 508	1 316	-	22	21	24	-
Ерөнхий боловсролын сургууль	35 110	31 156	3 954	-	20	21	14	-
Бага	11 820	10 481	1 339	-	31	33	20	-
Дунд	15 399	13 730	1 669	-	15	16	10	-
Ахлах	7 891	6 945	946	-	13	13	11	-
Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага	2124	1630	494	-	20	19	25	-
Дээд боловсролын сургалтын байгууллага	6 102	3 769	2 170	163	24	21	29	42

Улсын хэмжээнд 2021/2022 оны хичээлийн жилийн эхэнд СӨБ-д нийт 191.0 мянган хүүхэд хамрагдаж байгаагийн 178.4 (93.4%) мянга нь үндсэн сургалтад хамрагдаж байна.

Уг үзүүлэлтийг бүлгээр харвал 67.5 (37.8%) мянга нь бэлтгэл бүлэгт, 60.5 (33.9%) мянга нь ахлах бүлэгт, 40.7 (22.8%) мянга нь дунд бүлэгт хамрагдаж байна.

Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт энэ хичээлийн жилд 24 болж өмнөх хичээлийн жилээс 5-аар буурахад өмнө дурдсанчлан ковид-19 цар тахлын улмаас бүлэг дүүргэлтийг 20-25 байхаар зааж, 3 настай хүүхдийг цэцэрлэгт хамруулаагүйтэй холбоотой.


ЗУРАГ 1. ЦЭЦЭРЛЭГИЙН БҮЛЭГ ДҮҮРГЭЛТ, хүүхдээр, хичээлийн жилийн эхэнд



Энэ хичээлийн ЕБС-д 712.4 мянган сурагч суралцаж байгаагийн 371.5 (52.1%) мянга нь бага ангид суралцаж байна.

2021/2022 оны хичээлийн жилийн эхэнд ЕБС-ийн бага ангийн бүлэг дүүргэлт хөдөө орон нутагт стандарт хэмжээнд байна. Харин нийслэлийн Сонгинохайрхан, Чингэлтэй, Багануур, Баянгол, Налайх дүүрэгт бага ангийн бүлэг дүүргэлт 36-38 байгаа нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд (хуучин нэрээр), Сангийн сайдын хамтарч баталсан стандартад анги дүүргэлтийг бага ангид 30-35 хүүхэдтэй байхаар тогтоосноос давсан байна.

ЗУРАГ 2. ЕБС-ИЙН БАГА АНГИЙН БҮЛЭГ ДҮҮРГЭЛТ, хүүхдээр, нийслэл, дүүргээр, 2021/2022 оны хичээлийн жилийн эхэнд




Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчид 2021/2022 оны хичээлийн жилийн эхэнд 42.6 мянга болж, өмнөх хичээлийн жилээс 2.4 (6.1%) мянгаар нэмэгджээ. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчдын тоо нэмэгдсэн нь сар бүр оюутнуудад тэтгэлэг олгож байгаатай холбоотой байна.

Их, дээд сургууль, коллежид 149.0 мянган оюутан суралцаж байгаа нь өмнөх хичээлийн жилээс 1.7 (1.1%) мянгаар нэмэгдсэн байна. Их, дээд сургууль, коллежид суралцагчдын 117.0 (78.6%) мянга нь бакалаврын түвшний сургалтад хамрагдаж байна.

Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг суралцаж буй мэргэжлийн чиглэлээр авч үзвэл, 2021/2022 оны хичээлийн жилийн эхэнд нийт суралцагчдын 28.8 хувь нь бизнес, удирдахуй, хууль, эрх зүйн чиглэлээр, 17.5 хувь нь эрүүл мэнд, нийгмийн халамжийн чиглэлээр, 12.8 хувь нь инженер, үйлдвэрлэл, барилга угсралтын чиглэлээр, 12.2 хувь нь боловсролын чиглэлээр суралцаж байна.

ЗУРАГ 3. ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧИД, мэргэжлийн чиглэл, хүйсээр, 2021/2022 оны хичээлийн жилийн эхэнд



Ойлголт, тодорхойлолт:

Боловсрол: Өргөн утгаар нь мэдлэг, хандлага, ур чадвар олж авах, зан чанарын болон төлөвшлийн хувьд нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн, үнэлэгдсэн байр суурьтай болох насан туршийн үйл ажиллагааг ойлгоно.

Боловсролын үйл ажиллагаа: Эрдэм мэдлэг олгоход чиглэсэн харилцааны хэлбэрийг агуулсан зориудын үйл ажиллагааг хэлнэ.

Дээд боловсролын сургалтын байгууллага: Монгол Улсын “Боловсролын тухай хууль”-ийн 15.1-д заасны дагуу их сургууль, дээд сургууль, коллеж энэ ангилалд багтана.

Ерөнхий боловсролын сургууль: Монгол Улсын “Бага, дунд боловсролын тухай хууль”-д заасны дагуу боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага юм.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага: Монгол Улсын “Боловсролын тухай хууль”-ийн 14 дэх зүйлд зааснаар политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв зэрэг хэв шинжтэй байж болох бөгөөд политехник коллеж нь техникийн боловсролын сургалт эрхэлдэг байгууллага байна.

Сургалтын байгууллага: Монгол Улсын “Боловсролын тухай хууль”-ийн 3.1.5-д заасны дагуу боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлдэг хуулийн этгээдийг хэлнэ.

Сурагч-багшийн тооны харьцаа: Боловсролын тухайн түвшний боловсролын байгууллагад суралцагчдын тоог энэ түвшний багшийн тоонд харьцуулж тодорхойлно.



Эх үүсвэр:

Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны мэдээлэл

Ангилал, код:

Монгол Улсын боловсролын түвшний ангилал

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 10 дугаар сарын 17

Нийгмийн статистикийн
газрын дарга А.Амарбал
Утас: (976-51)-264805

Нийгмийн статистикийн
газрын статистикч М.Доржпагма
Утас: (976-51)-263966



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212